

гэнэ. Энэ ур дүйгээс Түмтэд хариуцлага тогтоох ур дүй тогтож, арга талын боловсролыг ХАН гэнэ. Билэг буюу биеийн дотоод ертөнцөд явагдах боловсролыг Ноён боловсрол гэнэ.

**.Хаан, хатаны хүүг Хан хүү гэнэ.** Хан хүү нараас нэг нь хаан болж бусад нь ноён болдог. Дээрхи онол дээр улсыг удирддаг хаан ба хатаны хүүхдүүдийг ийнхүү арга билэгээр зохистой болгожээ гэх мэт энэ судрын тайлал үргэлжилнэ. Хан хүү ба ноён яагаад Энэ 1-108 + 109-216 болдог юм бэ гэвэл:

“Түмт [ахуй төрт биед]-эд хариуцлага тогтоох ур дүй болбоос Хан ба ноён боловсрол болму” гэж сударт буй. Түмт гэдэг нь тэнгэрлэг байдалд хүрч ахуй төрт бие болсон тархин ГЭР-ийг өөрийн биедээ барьсан гэдэг утга учир ний-хэм байна. 1-108 + 109-216 бүхий мон-ын тоонуудын арга талын ур дүйг ХАН боловсрол, харин билэг талаар авч тайлбарлахыг Ноён боловсрол гэдэг. Өөрөөр хэлбэл: 1-216 хүртлэх 216 бодисыг ахуйн талаас тайлахыг Хан боловсрол, хүмүүний биеийн сүнслэг эрчим, бодол, сэтгэлийн эрчим талаас явагдах шүтэлцээгээр тайлахыг Ноён боловсрол гэнэ.

**Жонон \гүнж\ яагаад номын их хатан, 109-143 бүхий нөхөн гүйцээхийн бодис болдог юм?.** Жонон гэдгийг 2014 онд өртөөлөн буулгасан “Нүүдлийн соёл” номонд улаачийн биеэр буудаг тай жүй эрхит бууралыг хэлдэг гэж өтүгүн цагын буурал айлджээ. Хатан ухаанаар улаачийн биеийг хуяглан буусан жонон тайжүй эрхит нь Улаачийн бие ба гарыг ашиглан байгаль ба хүмүүнд хийх засалыг хатан ухаан гэнэ. Ямар засалыг яаж хийснийг хатан ухааны охин гэдэг ба, үр дүнг түлхүүр үгээр “гүнж” гэдэг. Энэ засалыг 109-143 бүхий 35 бодисын нөхөн гүйцээх эрдэм ашиглан засал хийгдэнэ. **Хатан ухааны охин** гэдэг нь үүнд явагдах 21 харилцаа байгаа ба аль харилцаанд тохируулах вэ гэдэг нь хатан ухааны ур дүй\ охин\ болно. Эрчмийн дутууг нөхөөд тэгш Хэм өгснийг **Гүнж** гэнэ. Охиноос “Түн жүй” зэрэгт хүрэх гэдэг утгатай түлхүүр үг юм. Энэ тухай ГЭР-ийн онол” номонд байгаа.

**Мянгатын мяндагтан яагаад номын их бичээч, 177-200 болдог юм бэ?.** Их Моногоуулын үед улсуудыг төвлөн удирдахдаа

Мянгатын гурван жанжин тавьж байсан. Төвшин цагт улсын амин нь бол цалигт, галигт, дуу уухайт гурван номын их мөргүд болно. Энэ номын их мөргүд нар дээрээс төрсөн номын бичээч нар гэдэг утгатай. Хүмэний биеийн ЭС-ийг бүрдүүлсэн 99 химийн бодис нь махан бие болохдоо 950 мөлүсү болдог байна. Би үүнийг 950 тэгштгэл гэж бичээд байгаа. Оносон эсэхийг хожмийн үрс мэдтүгэй. Гэр, Мон, Уялагын онол дээр оул биеэ гэгээрүүлж, боловсруулж, мэрэгшүүлж Чинд Чу Хажирьг жаяглаж Чингис Хааны огоуул зөнтэй болно гэдэг нь 950 мөлүсү тэгштгэл чинь 950 сэхээрэл биеийг олж байгаа гэсэн үг юм. Энэ бол “Улс Гэр амьдралын сүнс бие нь Чингис байдаг” “Сүнсний таван хүрдэн нь 950 мөл үсү болой” гэж сударт зааж сургасан онол юм. Тэгвэл Улс Гэр-ийн эзэн бие гэдэг нь биеийн хүчийг түмэн морины хүч нэмэх золбоо-чин засах Бөө Кү-эн хөх их засахуйн ертөнц гэж буй. Энэ бол махан биеийн засал юм. Задаар засах Бөө ИЭ Эн Гүн засахуйн их ертөнц гэж байгаа. Энэ бол бүхнийг өртөөлөн өрүүлэх, эрчимийн засал юм. Махан биеийн засалыг улаачийн 118-143, тайжүй эрхитийн 153-176 бүхий тавин бодисоор хамгаалалтын гар болгон амин эрчмийн засал-аар засагддаг тул  $950 + 50 = 1000$  болно. Үүнийг мянган хүнс ч сэхээрэл бие гэнэ. Мянган хүнсний эх булаг үйлдвэрлэг бие ба оюуны генитэй ний-Хэм-тэй болж байна гэсэн үг. Энэ бол улсын амин учир 177-200 амин дээд бодист хамаарч байна гэх мэт ойлгоно.

**Зуутын захирагч нь яагаад Номын эзэн, химийн 100-р бодис болдог юм бэ?**

1-108-д 153-216 эрчим ирэхэд 144-152-р бүхий есөн бодис хойноос ирэх бүх эрчмийг нийлмэл байдлаар хүлээн авч, биетийг бүрдүүлсэн 1-108 бодис тус бүрийн атомын задралын 9-р задралыг идэвжүүлэхэд 109-143 хүртлэх 35 бодис нөхөн гүйцээх үед 101-108 бодис нь бүх эрчмийг Эн болгоно. Хамгийн сүүлд 100-р бодис оломлон баталгаажуулдаг. Энэ бол 108 төвшин сайхан болно. Хэрэв муу санаа гаргавал эрчим доголдож 101-108 хүртлэх найман бодис нь эрчмийг ЭН болгох үйл нь доголдож эрчим

туяаны гажуудал үүсэж, 108 төвшин сайхан нь бүр цаашилбал 100 болж 100-р бодис ганцхан оломлохтойгоо үлдэнэ гэдэг онол юм. Яагаад номын эзэн гэдэг вэ? Зөв номоор амьдарч Ний-Хэмийг сонгох уу? Арван гурван хижи зүг гулсаж буруу номоор амьдарч Ний-Гэмийг сонгох уу? гэдэг энэ учир “номын эзэн” мөн болно.

**Аравтын ахлагч, Дэмч яагаад 1-108 + 109-216 ахуй төрт бие болдог юм бэ?**

**“Цаг уур, орон зайгаас удамшилд зохистой кү Чин авагчийг дэмч гэмү”** гэж сударт буй. Арван түгээмэл ахуйгаа уялагын онолоор байгуулж удамшилт зохистой дэмийг кү сурлагат нүүдлийн соёлоор явуулж үл тасрахуйн долоон биеийг олсон малчин, ажилчин түм -эн-ээс эхлээд хаан хүртлэх бүх хүмэнд хамаарна. Удамшил төгс элит хүмэн бол улсуу орондоо дэмтэн болно. Тэгээд “Хан” “ноён” боловсролоор Кү-эн долоон бие олсон тул МОН-ын тоо ижил байна. Хан боловсрол нь одоо бидний мэдэх арга талын боловсрол, ноён боловсрол нь ахуй биеийн дотор явагдах билэг эрчмийн боловсрол болно. Энэ бол ахуйт төрт биетэй дэмчийг төрүүлдэг гэдэг утгатай.

**Тавтын дарга, оюунтан нь яагаад 201-216 бодис болдог юм бэ?**

Ахуй төрт биеийг удамшил төгсөөр дэмч зэрэгт хүргэсэн тул таван тусгаар тогтнол, таван тусгаар эрдэнээ хамгаалсан тул оюунтан болно. Сүнс бие нь “оюуны нэү Мон” чанар болсон тул 201-216 дээд бодист оршихуйгаа хамгаалуулна гэсэн үг. Үүнд бол оюун ухаан, цус, эс ба ген, ясны оршихуйн мөн чанарыг байлгах гэх мэт хар, цагаан, шар, хөх туяа\эрчим\ байгаа. Аливаа ахуйн аминийг 177-200 дээд бодис хамгаална. Оршин байхуйн мөн чанарыг 201-216 дээд тоба бодис хамгаална.

**Гуравтын гутаагтан, шавь, яагаад 153-216 болдог юм бэ?.**

Ахуйн, Хүслийн, Улсын, Үүслийн, Оршихуйн ТНГР харилцааг олж, Аайий ЭЛ, Хаан, Таван тусгаар тогтнол эрдэнэдээ ургасан тул оюун сүнс бие нь атаа таван тэнгэрт гарах эрх олж 153-216 эрчмийн хамгаалалт, амин, оршихуйд хадгалагдаж, эргээд уругт мэндлэх, улаачаар буух, шар туяагаар мэдлэх өртөөлөх гэх мэт